

Маргааны товч

“Энержиресурс” ХХК-ийн “нүүрсний борлуулалтад илүү хэмжээгээр төлөгдсөн АМНАТ-ийг баталгаажуулах, цаашид хувь, хэмжээг Тогтворжуулах гэрчилгээ олгосон үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хууль тогтоомжийн дагуу тооцуулан АМНАТ ногдуулан төлж тайлагнаж байх арга хэмжээ авч өгөх” талаар гаргасан хүсэлтэд Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газар 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01/352 дугаар албан бичгээр “илүү төлөгдсөн гэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг баталгаажуулах хүсэлт нь Засгийн газрын тогтоолд заасан борлуулалтын үнэлгээ тооцох аргачлалын зөрүү, уг зөрүү нь Тогтворжуулах гэрчилгээнд заасан хувь, хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж үүсээгүй” гэж үзэн татгалзсан хариу хүргүүлсэн.

Нэхэмжлэгчээс “АМНАТ-ийн хувь, хэмжээг тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчийн бодит борлуулалтын орлогыг 30 хүртэл хэмжээнд нэмэгдүүлэн төлүүлсэн үйл ажиллагаа нь компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн” гэх үндэслэлээр маргасан.